



**МОНГОЛЫН ЗАГАСЧЛАЛЫН СПОРТЫН ХОЛБОО
ФЛАЙ ФИШИНГИЙН УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН**



Улаанбаатар хот

2024.07.01

УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Монголын загасчлалын спортын холбооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зохион байгуулагдаж буй Флай фишингийн улсын аварга шалгаруулах тэмцээн нь спорт загасчлалыг зөв зохистой хөгжүүлэх, туршлага солилцох, байгаль дэлхийтэй зөв харьцах, эв нэгдлийг эрхэмлэх зэрэг үнэт зүйлсэд тулгуурлан явагдана.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Загасчлалын спортын Чоно клуб.

ГУРАВ. ДҮРЭМ

Флай фишингийн ДАШТ-ний /FIPS-Mouche/ дүрмээр явагдана. Нэмэлт мэдээллийг хавсралт-1 дээр тусгав.

ДӨРӨВ. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Баг тус бүр 4 тамирчинтай байх бөгөөд 4 секторт 4 үеийн турш өрсөлдөнө. Үе тус бүрийн үргэлжлэх хугацаа 150 минут байна.

Багуудын бүрэлдэхүүнд дасгалжуулагч болон нөөц тамирчин багтсан бол мэдүүлэгт заавал хавсаргана.

ТАВ. БАЙРЛАЛ

Монгол улс, Төв аймаг Мөнгөнморьт сум, Хэрлэн гол

ЗУРГАА. ШҮҮГЧ

Тэмцээний ерөнхий шүүгчийн удирдлаган доор Монголын загасчлалын спортын холбоонд бүртгэлтэй шүүгчээр ахлуулсан зохион байгуулагч талын шүүгчдийн бүрэлдэхүүн шүүнэ.

ДОЛОО. ШАГНАЛ

Тэмцээнд оролцогчдыг багийн болон хувийн дүнгээр эхний 3 байр эзлүүлэх ба хувийн дүнгээр эхний 3 тамирчинд ивээн тэтгэгчийн шагнал олгохоос гадна хувийн дүнгийн эхний 10 байрт загасчлалын спортын цол, зэргийн оноо олгоно.

НАЙМ. ТЭМЦЭЭНИЙ ХУРААМЖ

Багийн хураамж 800.000 төгрөг бөгөөд оролцох багууд ХААН банкны 5300552794 тоот дансанд /данс эзэмшигч: Дашбилэг Уранбилэг/ багийн нэр болон холбогдох утасны дугаарыг гүйлгээний утга дээр бичиж илгээснээр бүртгэл баталгаажна.

ЕС. БҮРТГЭЛ

Тэмцээний бүртгэл 2024.07.20-ны өдрийг дуустал явагдана. Багийн мэдүүлгийг ***uuugiii892@gmail.com*** цахим хаягаар илгээнэ үү.

АРАВ. ХОЛБОО БАРИХ

Чоно клуб зохион байгуулах бүрэлдэхүүн С.Оюунбат 99105340, М.Наранцогт 99145836, Э.Идэр 99079277, Б.Хосбаяр 91916612, Д.Уранбилэг 99111367, Г.Давааням 99029354

Хавсралт-1

- Загасны зөвшөөрөгдөх доод хэмжээ 20см байна. /20-20.5см хүртэлх загасыг 20см-ээр, 20.5-20.9см хүртэлх загасыг 20.5см гэж тоолно/
- Тэмцээний секторуудын шугамыг татсаны дараа сектор дотор бэлтгэл хийх, загасчлахыг хатуу хориглоно. Хэрэв баг тамирчдаас зөрчил илэрвэл улаан карт олгож тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авна.
- Дүрэм зөрчиж барьсан тохиолдолд секторын шүүгч тамирчны лидер, флайг шалган хэмжилт хийж барьсан загасыг буцаан тавих эрхтэй.
- Тэмцээний үе эхлэхийн өмнө секторын шүүгч өөрийн секторын тамирчдыг бүртгэнэ.
- Тамирчдын салаалсан флайд загас зэрэг орохоос бусад тохиолдолд газардуулагч торонд нэгээс илүү тооны загас байхыг хатуу хориглоно.
- Хэвлэл мэдээлэл болон зураглаач нар зохион байгуулагчдын мандатаар нэвтрэх бөгөөд тухайн бүсэд байрлах тамирчны зөвшөөрлөөр эрэг рүү ойртоно.
- Тэмцээний аливаа үеийн туршид согтууруулах ундаа хэрэглэх, хэрүүл маргаан гаргахыг хатуу хориглоно. Тухайн зөрчил гаргасан тамирчин болон дасгалжуулагчийг тэмцээний ерөнхий шүүгч улаан картаар торгож тэмцээнээс хасах эрхтэй.
- Оролцогч нь тэмцээний үеийн туршид багийн мэдээллийг дамжуулахын тулд гар утас, радио эсвэл бусад цахилгаан харилцааны аргыг ашиглахыг хориглоно.
- Оролцогч нь тэмцээний үеийн туршид хэн нэгнээс (өөрийн багийн ахлагчаас бусад) загасчлахтай холбоотой зөвлөгөө авахыг хориглоно.
- Бүх флайг сэртэнгүй дан дэгээнүүд дээр ороосон байх.
- Амьдруулагч торыг голын цаана авч гарахгүй байх.
- Тамирчид амьдруулагч торыг өөрсдөө хариуцна.
- Тамирчдын сугалсан сугалааг зориулалтын энгэрийн тэмдэг дээр байрлуулж өгөх бөгөөд түүнийг тэмцээний турш шүүгчдэд харагдахуйц газар зүүнэ.
- Баг тамирчид аюулгүй байдлын зөвлөмжтэй танилцаж гарын үсэг зурна.
- Тамирчдын тоогоор хоолны талон тараах бөгөөд хаяж үрэгдүүлэхгүй байхад анхаарах.
- Хоолны талон нэмж авах бол зохион байгуулагч талд урьдчилан мэдэгдэн төлбөр төлж нэмэлтээр авч болно.
- Тэмцээний үеэр зохион байгуулагч талын зөвлөсөн талбайд отоглоно.
- Зөвшөөрөгдсөн талбайд бие засах ба ил задгай хог хаяхгүй байрлах.
- Хөтөлбөрийн дагуух цагийн хуваарийг баримтална.